

Хөдөлмөр засал” хөтөлбөрийн цогц чадамж: Номинал бүлгийн техниктэй хослуулсан Дельфийн зөвшилцлийн судалгаагаар боловсруулсан нь

С.Булганчимэг¹, М.Эрдэнэцэцэг¹, О.Батгэрэл³

Б.Солонго², Б.Оюунгоо¹

¹АШУУИС, Сувилахуйн Сургууль

²АШУУИС, Анагаах Ухааны Сургууль

³ШУГТЭ

Цахим шуудан: Bulganchimeg.s@mnums.edu.mn, Утас: 88096196

Түлхүүр үг:

Хөтөлбөрийн үр дүн (PLO), төгсөлтийн өмнөх, ахисан түвшин, хөдөлмөр засал, цогц чадамж

Товч утга

Үндэслэл: Хөтөлбөрийн сургалтын үр дүн нь тухайн оюутны хөтөлбөрийн төгсгөлд эзэмших ёстой мэдлэг, чадвар, хандлагаар тодорхойлогддог. Хөдөлмөр засалч мэргэжилтний төгсөлтийн өмнөх болон дараах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэн төгсөгчдөөс нийгэмд хүлээгдэж буй үр дүнг тодорхойлох шаардлагатай байна.

Зорилго: “Хөдөлмөр засалч” мэргэжилтэн бэлтгэхэд шаардлагатай төгсөлтийн өмнөх болон дараах цогц чадамжийг тодорхойлох.

Арга, аргачлал: Бид өөрчлөгдсөн дельфи арга ба номинал бүлгийн (NG) техникийг ашигласан. Энэхүү судалгааг 2022 оны 4-р сараас 2024 оны 5-р сар хүртэл гурван үе шаттайгаар явуулсан.

Үр дүн: Онлайн санал асуулгад нийт 136 хүн оролцсон. Дэлхийн хөдөлмөр заслын холбооноос гаргасан Хөдөлмөр заслын боловсролын босго стандарт, Канадын хөдөлмөр засалчдын үйл ажиллагааны тодорхойлолт 2012, Европ дахь хөдөлмөр заслын боловсролын “TUNING” дахь цогц чадамжуудын нэгтгэн үнэлгээнд зориулж номинал бүлэг (NG) нь асуултыг агуулсан албан ёсны жагсаалтыг гаргасан. Номинал бүлгийн уулзалт (NG) 5 удаагийн уулзалт, нэг удаагийн санал, дахин давтан асуумж үнэлгээний дараа хөдөлмөр заслын хөтөлбөрийн үр дүн (PLO) болох 12 ур чадвар, төгсөлтийн өмнөх 198, төгсөлтийн дараах 86 цогц чадамжийг тодорхойлсон.

Дүгнэлт: Зөвшилцлийн арга техникийг ашигласнаар бид Хөдөлмөр заслын хөтөлбөрийн үр дүн (PLO) болох 12 ур чадварыг бүрэн эзэмшихэд хөдөлмөр засал хөтөлбөрийн үндсэн болон ахисан түвшний чадамжуудын жагсаалтыг гаргасан бөгөөд энэ нь ирээдүйн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрүүдэд лавлагаа болж болох юм.

Үндэслэл: Сүүлийн үед анагаах ухааны боловсрол судлал нь уламжлалт сургалтын арга барилаас дэвшилтэт, нотолгоонд суурилсан сургалтын загвар, багцалсан чадамжид суурилсан хөтөлбөр, цахим болон симуляцийн сургалтыг түлхүү хөгжүүлэх чиглэлд шилжиж байна. Дэлхий дахинд төгсөгчдийн эзэмшвэл зохих хичээлийн үр дүн (CLO), хөтөлбөрийн хүрэх үр дүнг (PLO)-г тодорхойлох нь сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх, сургалтын үйл явцыг боловсронгуй болгох чухал суурь болдог. Тухайлбал, Фрэнк нар анагаах ухааны боловсролын ирээдүйн чиг

хандлагыг “салбар дамнасан, интеграцчилсан, системчилсэн” шинэчлэл гэж тодорхойлсон бол, Текиан нар (2020) нар нь сургалтын үр дүнд суурилсан боловсролын ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн байдаг¹⁻³. Монгол Улсын хувьд ч энэ чиг хандлага тодорхой болж, дээд боловсролын байгууллагууд сургалтын үр дүнд суурилсан шинэчлэлийг хэрэгжүүлэх, боловсрол судлалын үндэслэл бүхий судалгааг дэмжих замаар сургалтын чанарыг ахиулахад анхаарч байна.

Хөдөлмөр заслын хөтөлбөрийн хичээлийн үр дүн (CLO)-ыг тодорхойлох нь сургалтын

чанарыг сайжруулах, төгсөгчдийн ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд чухал ач холбогдолтой. Хичээлийн үр дүн (CLO)-гууд нь төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, ёс зүй, багаар ажиллах чадварыг тодорхойлж, энэ нь сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний системийг удирдах боломжийг олгодог. Хөдөлмөр заслын хөтөлбөрийн хичээлийн үр дүн (CLO)-ууд нь зөвхөн академик мэдлэг бус, мэргэжлийн ур чадвар, шүүмжлэлтэй сэтгэх, судалгаа хийх, инновацийг дэмжих чадварыг хөгжүүлэхэд чиглэдэг. Дэлхий даяар Хөдөлмөр заслын үйлчилгээний хэрэгцээ өсч байгаа тул сургалтын чанарыг нэмэгдүүлэх, мэргэжилтнүүдийг бэлтгэхэд хичээлийн үр дүн (CLO)-гууд чухал үүрэг гүйцэтгэдэг ⁴⁻⁶.

Хөдөлмөр засал хувь хүний бие махбод, сэтгэл зүй, нийгмийн үйл ажиллагаанд тулгарч буй хязгаарлалтыг нөхөн сэргээж, бие даан амьдрах чадварыг дэмжихэд чиглэсэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний салшгүй чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд хөдөлмөр засалч бэлтгэх сургалтыг чадамжид суурилсан боловсролын тогтолцоонд шилжүүлэх хандлага эрчимжиж, сургалтын агуулга, үнэлгээний аргачлалд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагыг нарийн тодорхойлох шаардлага нэмэгдэж байна. Энэ хүрээнд олон улсын байгууллагууд чадамжийн жишиг баримт бичгүүдийг боловсруулсан бөгөөд үүнд: Дэлхийн хөдөлмөр заслын холбооны боловсролын босго стандарт (WFOT, 2016), Канадын хөдөлмөр засалчдын үйл ажиллагааны тодорхойлолт 2012 "Occupational Therapy Profile" (CAOT, 2012), мөн Европ дахь хөдөлмөр заслын боловсролын "TUNING" дахь хөдөлмөр заслын хөтөлбөрийн цогц чадамжууд (2016) багтана. Эдгээр баримт бичгүүд нь хөдөлмөр заслын сургалтын уялдаа холбоог хангах, чанарыг сайжруулах, төгсөгчийн чадамжийг тодорхойлох суурь болж байна ⁷⁻⁹.

Монгол Улсад бакалаврын хөдөлмөр засалч хөтөлбөрийг 2014 оноос эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд өдгөө тус мэргэжлийн төгсөлтийн өмнөх болон дараах шатны сургалтын хөтөлбөрийг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэн, боловсронгуй болгосоор байна. Энэхүү хөтөлбөрүүд нь олон улсынчиг хандлага, үндэсний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулагдсан хэдий ч тэдгээрийн хэрэгжилт, төгсөгчдийн чадамжийн хүрэх түвшин, нийгэмд үзүүлж буй үр нөлөөг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэлэх шаардлага урган гарч байна. Түүнчлэн хөдөлмөр засалч мэргэжилтнээс нийгэм, эрүүл мэндийн байгууллагуудын хүлээлт нэмэгдэж буй энэ үед төгсөгчдийн эзэмшвэл зохих цогц чадамжуудыг ил тод, хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж, хөтөлбөрийн (PLO) болон хичээлийн үр дүн (CLO)-г үндэслэн хөтөлбөрийн

үнэлгээ хийх нь чухал ач холбогдолтой болжээ. Иймд төгсөгчдийн мэргэжлийн цогц чадамжийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулан тодорхойлох нь хөдөлмөр засалч мэргэжлийн сургалтын чанарыг сайжруулах, цаашдын бодлогын шинэчлэлд чиглэл өгөх үндэслэл болж байна.

Зорилго: “Хөдөлмөр засалч” мэргэжилтэн бэлтгэхэд шаардлагатай төгсөлтийн өмнөх болон дараах цогц чадамжийг тодорхойлох.

Арга, аргачлал: Энэхүү судалгааг зөвшилцлийн аргыг ашиглан 2022 оны дөрөвдүгээр сараас 2024 оны тавдугаар сарын хооронд гурван үе шаттайгаар зохион байгуулсан (Зураг 1). I үе шатанд (Дельфи аргын эхний шат) хөдөлмөр заслын мэргэжлийн багш, төгсөгч, оюутан, холбооны гишүүд, бусад оролцогч талуудаас хөдөлмөр засалч мэргэжилтэн бэлтгэхэд шаардлагатай цогц чадамжийн талаархи санал бодлыг цуглуулах зорилгоор жагсаалтыг цахим санал асуулгыг онлайн аргаар түгээсэн. II үе шатанд (Номинал бүлгийн техник) цогц чадамжийн жагсаалтыг гаргахын тулд хэд хэдэн нүүр тулсан уулзалтаар хөдөлмөр засалч мэргэжилтнээс хүлээгдэж буй чадамжуудын талаар санаа, байр суурийг нэгтгэсэн санал хураалтыг явуулсан. III үе шатанд (Дельфи аргын хоёр дахь шат) сайжруулсан жагсаалтыг дахин түгээж, нэгдсэн зөвшилцөлд хүрч, эцсийн баталгаажуулалтыг хийсэн. Судалгааны туршид үндэсний болон олон улсын жишиг хөтөлбөр, стандартуудыг харьцуулан судалгаа боловсруулалтад тусгасан.

Судалгаанд нийт 83 хүн оролцсон бөгөөд оролцогчдод хөдөлмөр заслын мэргэжилтнүүд, хөтөлбөрийн төгсөгчид, оюутнууд болон мэргэжлийн холбооны гишүүд багтсан. Оролцогчдын олон талт саналыг нэгтгэн, чадамжийн жагсаалтыг боловсруулсан. (Зураг 1)



Зураг 1. Судалгааны үе шатын бүдүүвч

I үе: Цогц чадамжийн жагсаалтыг нэгтгэн гаргах (Дельфи аргын эхний шат)

Цогц чадамжийн жагсаалтыг Дэлхийн хөдөлмөр заслын холбооны боловсролын босго стандарт (WFOT, 2016)⁷, Канадын хөдөлмөр засалчдын үйл ажиллагааны тодорхойлолт "Occupational Therapy Profile" (CAOT, 2012), мөн Европ дахь хөдөлмөр заслын боловсролын "TUNING" дахь хөдөлмөр заслын хөтөлбөрийн цогц чадамжууд (2016)⁹ гэх гурван эх сурвалж болон нэг нээлттэй асуултаар бэлдсэн.⁸ Эдгээр гурван эх сурвалжийн чадамжуудаас агуулгын хувьд давхардсан ойлголтуудыг нэгтгэн жагсаалтыг хялбарчилсан. Жишээ нь: Дэлхийн хөдөлмөр заслын холбооны боловсролын босго стандартын "Өөрийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагынхаа цар хүрээг дүгнэх чадвартай байх", Канадын хөдөлмөр засалчдын үйл ажиллагааны тодорхойлолтын "Өөрийн хязгаар, ур чадварын талаарх ойлголтыг үзүүлэх" Европ дахь хөдөлмөр заслын боловсролын "TUNING"-гийн "Хөдөлмөр засалч хүний хувьд өөрийгөө удирдах чадвар, өөрийгөө ухамсарлах чадвар, хязгаарлагдмал байдлын талаарх мэдлэгээ харуулах" зэргийг агуулгыг нэг асуулт болгож багцалсан. Асуултын жагсаалтыг монгол хэлээр 6 үндсэн бүлэгт хуваан гүүглэ формыг ашиглан мэдээлэл цуглуулсан. Судалгаанд оролцогсад асуулт тус бүрийг "тийм", "үгүй" гэсэн хариултын аль нэгийг сонгох бөгөөд нэг нээлттэй асуулт нь "Хөдөлмөр засалчид дээрх цогц чадамжуудаас гадна ямар мэдлэг, чадвар, хандлага шаардлагатай байна вэ?" байв. Онлайн асуумжийг 45 хоногийн турш цахим сүлжээнд байршуулсан. Нээлттэй асуултын давхардсан санааг нэгтгэж, ойлгомжгүй хариултыг хасаж цогц чадамжийн жагсаалтаас дор хаяж нэг "тийм"

гэсэн хариулттай асуултыг авч номинал бүлгийн уулзалтыг жагсаалтыг бэлтгэв.

II үе: Номинал бүлгийн нүүр тулсан уулзалт (Номинал бүлгийн техник)

Хөдөлмөр засал хөтөлбөрийн цогц чадамжийг тодорхойлох зорилгоор хөдөлмөр заслын багш, гадаадад магистрт сурч байгаа хөдөлмөр заслын төгсөгч, сэргээн засах салбарт олон жил ажилласан туршлагатай эмч, дээд боловсролын чиглэлээр бодлогын түвшинд ажиллаж мэргэшсэн мэргэжилтэн зэрэг өөр өөр туршлагатай экспериийн бүлгийг (NG) 4 гишүүнтэй үүсгэсэн. Хөтөлбөрийн хүрэх үр дүн (PLO), цогц чадамжийн бүлэг, хичээлийн хүрэх үр дүн (CLO)-г төгсөлтийн өмнөх болон дараах байдлаар тодорхойлохыг зорьсон бөгөөд үйл явц 5 үе шаттайгаар явагдсан. Эхний шатанд гишүүдэд онлайн судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан чадамжуудын жагсаалтыг имэйлээр илгээж, тус бүрийн ач холбогдлыг 5 онооны Лайкертийн шатлалаар үнэлэхийг хүссэн байна. 100% гишүүдийн 4 эсвэл 5 оноо авсан чадамжуудыг шууд эцсийн жагсаалтад оруулсан бол цогц чадамжуудыг дараагийн шатанд шилжүүлсэн.

Хоёр дахь шатанд 2023 оны 4-р сарын 21-нд нүүр тулсан уулзалт зохион байгуулагдаж, гишүүд чухал гэж үзсэн таван чадамжаа сонгон, сонголтынхоо шалтгааныг тайлбарласан байна. Энэ шатанд мөн 100% санал нэгдсэн чадамжуудыг эцсийн жагсаалтад оруулсан бол үлдсэн чадамжуудыг дараагийн шатанд шилжүүлсэн байна. Гурав болон дөрөв дэх шатанд ижил аргаар үнэлгээ хийсэн боловч 100% санал нэгдсэн чадамжууд гараагүй тул тухайн чадамжуудыг жагсаалтаас хассан байна. Тав

дахь шатанд 2023 оны 6-р сарын 22-нд гишүүд тус бүрийн цогц чадамжийг блүүмийн таксономоор төгсөлтийн өмнөх дараахаар тодорхойлсон. Ихэнх санал авсан түвшинг эцсийн сонголт болгон хүлээн зөвшөөрсөн бөгөөд санал тэнцсэн тохиолдолд доод түвшинг сонгожээ. Номинал бүлгийн (NG) бүх гишүүд таван шатны үнэлгээнд бүрэн оролцсон¹⁰.

III үе: Сүүлийн шатны давтан санал асуулга (Дельфи аргын хоёрдугаар шат)

Сүүлийн цогц чадамжийн жагсаалтыг адил гүүглэ форм ашиглан эхний шатанд оролцсон оролцогчдоос санал асуулгыг хүлээн авсан ¹¹.

Төгсгөлийн шатны хөгжүүлэлт: Судалгааны гурван үе шат дууссаны дараа “хөтөлбөрийн хүрэх үр дүн (PLO)”, “Цогц чадамжийн бүлэг”, “цогц чадамж/ хичээлийн хүрэх үр дүн (CLO)-г төгсөлтийн өмнөх болон дараах” гэсэн байдлаар тодорхойлсон. Асуумжийн үр дүнг боловсруулахдаа SPSS-21.00 программыг ашиглан дүрслэх статистикийн боловсруулалт хийсэн.

Судалгааны ёс зүй: “Үр дүнд суурилсан сургалтын загвар боловсруулж, мэргэжлийн хөгжлийн ерөнхий зураглалыг тодорхойлсон нь (Хөдөлмөр засал хөтөлбөрийн жишээн дээр)” сэдэвт судалгааны ажлыг 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн №2020/3-05 тоот АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны хурлын шийдвэрээр судалгааны ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг авсан.

Үр дүн

I үе: Цогц чадамжийн жагсаалтыг нэгтгэн гаргах (Дельфи аргын эхний шат)

Делфийн эхний шатанд хөдөлмөр засал хөтөлбөрийн бүх оролцогч талуудаас төлөөллүүдийг хамруулж нийт 83 хүн санал асуулгад оролцов (Хүснэгт 1). Нийт оролцогчдын 43 (51.8%) 3 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ ажилласан ба хүүхдийн хөдөлмөр засалчид хамгийн олон 15 (18.2%) байв.

Хүснэгт 1. Дельфи онлайн санал асуулгад оролцогчид

Мэргэжилтэн	1-р үеийн Дельфи	2-р үеийн Дельфи
Хүүхдийн хөдөлмөр засалч	15 (18.2%)	12 (22.6%)
Гэмтлийн хөдөлмөр засалч	11 (13.4%)	10 (18.8%)
Мэдрэлийн хөдөлмөр засалч	11 (13.4%)	9 (16.9%)
Настны хөдөлмөр засалч	7 (8.5%)	4 (7.1%)
Багш	2 (2.4%)	2 (3.5%)
Оюутан	26 (31.7%)	11 (21.4%)
Бусад сэргээн засахын мэргэжилтэн	11 (12.1%)	5 (8.9%)
Нийт	83	53

Эхний онлайн асуулгын асуулт бүрт дор хаяж нэг санал авсан тул бүгд номинал бүлгийн (NG) үнэлгээнд орсон. Үндсэн жагсаалтыг устгахгүйгээр зөвхөн нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх дүрмийг баримталж 346 саналыг агуулсан албан ёсны жагсаалтыг номинал бүлгийн (NG) үнэлгээнд зориулж гаргасан. Нээлттэй асуултад 56 нэмэлт санал ирсэн бөгөөд эхний онлайн асуулгад орсон болон давхцыг арилган 22 санал (мэдлэг- 6, ур чадвар-7, хандлага -9) нэмж оруулсан.

II үе: Номинал бүлгийн нүүр тулсан уулзалт (Номинал бүлгийн техник)

Эхний шатны үнэлгээний үеэр 163 (44.3%) зүйл бүрэн зөвшилцөлд хүрсэн. Дараа нь хоёр, гуравдугаар шатанд 28 (7.6%), 7 (1.9%) санал хураалт явуулжээ. Дөрөв дэх шатанд нэмэлт зүйл бүрэн зөвшилцөлд хүрээгүй тул үнэлгээг дуусгавар болсон. Эцэст нь 198 зүйл агуулсан жагсаалтыг гаргав. Бүрэн зөвшилцөлд хүрээгүй өөр 170 асуултыг хассан. Тав дахь

шатны үнэлгээгээр төгсөлтийн өмнөх 198 цогц чадамжаас 86 цогц чадамжийг төгсөлтийн дараах сургалтанд блүүмийн таксономоор тодорхойлсон. Мөн хөтөлбөр 12 хүрэх үр дүн, цогц чадамжийг 5 үндсэн бүлэг ангиллаа.

III үе: Сүүлийн шатны давтан санал асуулга (Дельфи аргын хоёрдугаар шат)

Сүүлийн шатны давтан санал асуулгад өмнөх оролцогчдоос 53 (63.8%) хүн оролцсон бөгөөд шинэ ур чадвар санал болгоогүй тул цогц чадамжийн жагсаалтад өөрчлөлт ороогүй болно (хүснэгт 1). Хөдөлмөр заслын хөтөлбөрийн үр дүн (PLO) болох 12 ур чадвар, төгсөлтийн өмнөх 198 (Мэдлэг-79, Чадвар-86, Хандлага-33), төгсөлтийн дараах 86 (Мэдлэг-41, Чадвар-33, Хандлага-12) тус тус цогц чадамжийг тодорхойлж “Хүн-орчин-хөдөлмөр хоорондын болон хүний эрүүл мэнд сайн сайхан байдалд хөдөлмөрийн харилцаа холбоо”, “Эмчилгээ болон мэргэжлийн харилцаа холбоо”, “Хөдөлмөр заслын үйл явц”,

“Мэргэжлийн сэтгэлгээ зан байдал”, “Мэргэжлийн практик үйл ажиллагааны нөхцөл байдал” гэсэн 5 бүлэгт ангиллаа.

Хэлцэмж: Судалгааны үр дүнг олон улсын ижил төстэй судалгаатай харьцуулахад, хэд хэдэн ижилсэл, ялгаа ажиглагдаж байна. Австралийн Occupational Therapy Australia байгууллагаас 2018 онд шинэчлэн баталсан чадамжийн стандарт нь мэргэжлийн хариуцлага, ёс зүй, хамтынажиллагаа, харилцаа, шүүмжлэлт сэтгэлгээ, соёлын аюулгүй байдал зэрэг чиглэлд голчлон төвлөрдөг.¹² Манай судалгааны үр дүнгээр тодорхойлогдсон цогц чадамжууд ч эдгээр чиглэлийг тусгасан бөгөөд үндэсний хөтөлбөр олон улсын стандарттай уялдах боломжтойг харуулж байна. Японы эрдэмтэд, тухайлбал Фүжимото нарын хөдөлмөр засалчийн цогц чадамжийг тодорхойлоход Дельфи арга ашигласан судалгаагаар “үйлчлүүлэгч төвтэй хандлага,” “хамтран ажиллах чадвар,” “байнгын суралцах хандлага” зэрэг чадамжийг онцолжээ. Манай судалгаанд мөн эдгээр чадамжууд тусгагдсан нь бүс нутгийн түвшинд ижил төстэй чиг хандлага байгааг илтгэж байна. Гэвч манай судалгааны онцлог нь зөвхөн чадамж тодорхойлоод зогсохгүй, тэдгээрийг сургалтын хөтөлбөрийн бүтэц, агуулгатай системтэй уялдуулсан явдал юм. Канадын судлаачдын судалгаагаар олон улсын эрүүл мэндийн боловсролын хүрээнд чадамжийн суурь ойлголтыг тодорхойлж, мэргэжлийн үр чадвар, ёс зүй, манлайлал, хамтын ажиллагаа зэргийг “цогц чадамж” болгон тодорхойлсон байдаг.¹³ Энэ нь манай судалгаанд онцгойлон тусгасан манлайлал, мэргэжлийн хөгжлийн талаарх чадамжуудтай дүйж байна. АНУ-ын Хөдөлмөр заслын холбооны (American Occupational Therapy Association) боловсруулсан “Occupational Therapy Practice Framework” баримт бичигт хөдөлмөр засалчдын мэдлэг, үр чадвар, мэргэжлийн туршлагын уялдаа, үйлчлүүлэгч төвт тусламжийг онцолсон нь манай судалгааны практик чадамжуудын агуулгатай ойролцоо байв.¹⁴

Төгсөлтийн өмнөх болон дараах чадамжийг тодорхойлох нь боловсролын чанар, сургалтын үр дүнг үнэлэхэд чухал ач холбогдолтой. Энэ ялгаа нь суралцагчдын хөгжлийн шатлалын мэдрэмжийг бий болгох бөгөөд төгсөлтийн өмнөх чадамж нь суурь мэдлэг, үр чадварыг эзэмшихэд, төгсөлтийн дараах чадамж нь мэргэжлийн өндөр

түвшний мэдлэг, хандлага шаарддаг. Мөн энэ нь сургалтын агуулга, арга зүйг сайжруулах, сургалтын үр дүнг үнэлэх боломжийг бүрдүүлж, төгсөгчдийг мэргэжлийн шаардлагад нийцсэн, практикт амжилттай хэрэгжүүлэх чадамжтай болгоход хувь нэмэр оруулдаг. Олон улсын түвшинд хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн чадамжийн чанар, шаардлагыг бүрдүүлж, сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсронгуй болгох үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг¹⁵.

Ийнхүү олон улсын жишээтэй харьцуулахад үндэсний нөхцөлд суурилсан, харьцангуй өргөн хүрээтэй оролцогч талуудыг хамруулсан, хөтөлбөрийн зорилго ба чадамжийн уялдааг бүрэн тодорхойлсон нь давуу тал болж байна. Гэсэн хэдий ч судалгаанд хамрагдсан хүмүүсийн тоо болон төлөөллийн хязгаарлагдмал байдал, зөвхөн нэг их сургуулийн жишээн дээр суурилсан зэрэг нь ерөнхийлөл хийхэд тодорхой хязгаарлалттай. Цаашид энэхүү цогц чадамжийн хүрээг практикт хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэх, хураангуйлан нэгтгэж хичээлийн хүрэх үр дүн (CLO) тодорхойлох шаардлагатай байна.

Дүгнэлт: Зөвшилцлийн арга техникийг ашигласнаар хөдөлмөр засал хөтөлбөрийн сургалтын үр дүн (PLO)-г бүрэн хангах үндсэн болон ахисан түвшний цогц чадамжуудыг системтэйгээр тодорхойлж, найдвартай жагсаалт боловсрууллаа. Энэхүү цогц чадамжийн тогтолцоо нь хөдөлмөр засалч мэргэжлээр төгсөгчдийн мэдлэг, үр чадвар, хандлагын хөгжлийн шатлалыг тодорхойлох боломжийг бүрдүүлж, цаашдын сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, үнэлгээний шалгуурыг оновчтой болгох, цогц чадамжид суурилсан боловсролын хандлагаас үр дүнд суурилсан сургалтыг хэрэгжүүлэхэд практик ач холбогдолтой лавлагаа материал болох бүрэн боломжтой юм.

Талархал: Уг судалгааны ажил “Монгол улсын соёлын онцлогт тохирсон, тогтвортой хөгжих хөдөлмөр заслын чанартай боловсролыг хамтран бий болгох” (co-creation of sustainable and culturally relevant high quality occupational therapy education in mongolia) төслийн хүрээнд хийгдсэн бөгөөд төслийг санхүүжүүлсэн Хөдөлмөр Заслын Дээд Боловсролын Европын Сүлжээ (European Network of Occupational Therapy in Higher Education)-нд талархал илэрхийлье.

Ном зүй:

1. Frenk J, Chen L, Bhutta ZA, et al. Health professionals for a new century: transforming education to strengthen health systems in an interdependent world. *The lancet*. 2010;376(9756):1923-1958.
2. Schmuter G. Learning a second language: diversifying medical school from within. *Academic Medicine*. 2020;95(2):172.
3. Gruppen LD, Mangrulkar RS, Kolars JC. The promise of competency-based education in the health professions for improving global health. *Human resources for health*. 2012;10:1-7.
4. Organisation WH. *World report on disability*. World Health Organization; 2011.
5. World Federation of Occupational Therapists. *Global occupational therapy standards for education*. Published 2016. Accessed April 12, 2025. 2016.
6. American Occupational Therapy Association. *Occupational therapy educational*

- standards. 2018.
7. Therapists. WFOO. Minimum standards for the education of occupational therapists. . 2016.
8. Therapists. CAoO. Profile of Occupational Therapy Practice in Canada. 2012.
9. Kantartzis S, Ness NE. Developing subject specific competences and cycle level descriptors for occupational therapy in Europe through the Tuning process. *World Federation of Occupational Therapists Bulletin*. 2007;56(1):14-31.
10. Peña A, Estrada CA, Soniat D, Taylor B, Burton M. Nominal group technique: a brainstorming tool for identifying areas to improve pain management in hospitalized patients. *Journal of hospital medicine*. 2012;7(5):416-420.
11. Delbecq AL, Van de Ven AH. A group process model for problem identification and program planning. *The journal of applied behavioral science*. 1971;7(4):466-492.
12. Sellar B, Murray CM, Stanley M, Stewart H, Hipp H, Gilbert-Hunt S. Mapping an Australian Occupational Therapy curriculum: Linking intended learning outcomes with entry-level competency standards. *Australian occupational therapy journal*. 2018;65(1):35-44.
13. Battat R, Seidman G, Chadi N, et al. Global health competencies and approaches in medical education: a literature review. *BMC medical education*. 2010;10:94.
14. Occupational Therapy Practice Framework: Domain and Process-Fourth Edition. *The American journal of occupational therapy : official publication of the American Occupational Therapy Association*. 2020;74(Supplement_2):7412410010p7412410011-7412410010p7412410087.
15. Chan CK, Fong ET, Luk LY, Ho R. A review of literature on challenges in the development and implementation of generic competencies in higher education curriculum. *International Journal of Educational Development*. 2017;57:1-10.

Core Competencies of the Occupational Therapy Program: Consensus developed by a modified Delphi survey combined with the nominal group technique

Bulganchimeg S¹, Erdenetsetseg M¹, Batgerel O³, Solongo S², Oyungoo O¹

¹School of Nursing, Mongolian National University of Medical Sciences

²School of Medicine, Mongolian National University of Medical Sciences

³State Central Third Hospital, Ulaanbaatar, Mongolia

Email: Bulganchimeg.s@mnums.edu.mn, Tel: 88096196

Keywords:

Program Learning Outcomes (PLO), pre-graduation, advanced level, occupational therapy, core competencies

Background: The learning outcomes of a program are defined by the knowledge, skills, and attitudes that students are expected to acquire by the end of the curriculum. For occupational therapy professionals, it is essential to successfully implement both pre-graduation and post-graduation programs and to assess the effectiveness of the curriculum by clearly identifying the competencies expected of graduates in society.

Aim: To identify the core competencies required for training occupational therapists at both pre-graduation and post-graduation levels.

Materials and Methods: A modified Delphi method combined with Nominal Group Technique (NGT) was employed. The study was conducted in three phases from April 2022 to May 2024. In the initial online survey, a total of 83 participants were involved, including occupational therapy students, graduates, and members of the Mongolian Association of Occupational Therapists. A nominal group consisting of four experts held several focus group discussions to review and vote on the proposed competencies, forming a revised list. In the final phase (second-round Delphi), the updated list was distributed online again to collect additional feedback.

Results: A total of 136 individuals participated in the online surveys throughout the study. The final list of competencies was synthesized based on three main international standards: the World Federation of Occupational Therapists (WFOT) Minimum Standards for Education (2016), the Canadian Association of Occupational Therapists (CAOT) Profile of Occupational Therapy Practice (2012), and the TUNING Educational Competencies in Europe. Through five rounds of NGT meetings, one online scoring session, and a final Delphi round, a total of 12 program learning outcomes (PLOs), 198 core competencies for the pre-graduation level, and 86 competencies for the post-graduation level were identified.

Conclusion: By applying consensus techniques, we developed a structured list of core competencies at both the basic and advanced levels aligned with the 12 program learning outcomes (PLOs) of the occupational therapy curriculum. This list can serve as a practical reference framework for future curriculum design and professional training programs in the occupational therapy.